

3

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Г.Элдэв-Очир, Н. Энхамгалан

XVII зууны үед хөгжлийнхөө дээд оргилд хүрч байсан маркетингизмын онолд аливаа баялагийг бий болгох эх сурвалж нь гадаад худалдаа юм хэмээж баялаг зөвхөн гүйлгээний хүрээнд бий болно гэж үзэж байв. Энэ үзэл нь хэдийгээр алдаатай үзэл байсан хэдий ч гадаад худалдааны онолын үндэслэлийг тодорхойлсон нь эдийн засгийн шинжлэх ухааны хөгжилд чухал нэмэр болсон юм.

Шинээр аж үйлдвэржиж байгаа улс орнуудын хөгжлийн түвшингөөс үзэхэд эдийн засгийн гадаад сектор нь эдийн засгийн өсөлт, хөгжилтийн замыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэсэн үзлээр хандах болсон. Үнэндээ ч аливаа улс орон дан ганц өөрийн нөөц бололцоогоор улс орныг хөгжүүлэх бололцоо хязгаарлагдмал тул гадаад эдийн засагтай харьцах шаардлага зайлшгүй урган гардаг.

Монгол улсын хувьд эдийн засгийн нээлттэй бодлого баримталж эхэлсэнээр олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагад гишүүнээр элсэн орж идэвхитэй хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд олон улсад мөрдөж байгаа ангилал, заавар, журмаар эдийн засгийн үйл ажиллагаагаа хөтлөн явуулах боломжтой болж байгаа юм.

Энэхүү төлбөрийн тэнцлийн судалгаагаар төлбөрийн тэнцэл гэж юу болох, манай улсын төлбөрийн тэнцлийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд бусад улсуудынхтай харьцуулахад ямархуу түвшинд байдаг, төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүдийн прогнозчлолын талаар авч үзлээ.

Төлбөрийн тэнцэл гэдэг нь тодорхой хугацаанд тухайн улсаас гадаад эдийн засагтай хийсэн бүх төрлийн гүйлгээг нэтгэн харуулсан тайлан юм.

Төлбөрийн тэнцэл нь үндсэндээ урсгал тооцоо, капиталын тооцоо гэсэн хоёр гол хэсгээс бүрддэг. Урсгал тооцооны хэсэг нь бүтээгдэхүүн үйлчилгээний экспорт, импорт болон урсгал шилжүүлгүүдийг агуулж байдаг бол капиталын тооцоо нь

хөрөнгийн худалдан авалт болон борлуулалтын үйл ажиллагааг хамарч байдаг.

Орлого, зарлагын ямар ч системд төлбөрийн тэнцлийн тооцоо нь нягтлан бодох бүртгэлийн данс давхар бичилтийн зарчим дээр үндэслэгдсэн байдаг. Ийнхүү гадаад гүйлгээ заавал давхар бүртгэгдэх ба анхных нь уг гүйлгээ чухам юуных болохыг харуулдаг бол дараагийнх нь түүнийг хэрхэн яаж санхүүжүүлснийг харуулна. Үүний дүнд төлбөрийн тэнцэл нь үргэлж тэнцэж байдаг. Тэнцэж чадаагүй нөхцөлд тэнцүүрт оруулах олон сонголтыг хийдэг.

Төлбөрийн тэнцэл

	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997
Худалдааны тэнцэл	-578.8	-140	-62.6	-8.7	-3.5	-3.3	-87.4	-9.6
Экспорт (ФОВ)	444.8	346.5	355.8	365.8	367	485.6	423.4	493.7
үүнээс: зэс		213.1	160.1	155.1	188.7	257.6	174.5	211.3
зэсийн бус		133.4	195.7	210.7	178.3	228	248.9	282.4
Импорт (СИФ)	-1023.6	488.5	418.4	374.5	370.5	488.9	510.8	503.3
Үйлчилгээний тэнцэл	-72.6	-44.7	-25.4	-31.1	-33.8	-46.1	-18.1	-15.3
Орлого	53.1	26.5	35.2	26.8	43	47.1	69.1	60.9
Төлбөр	-125.7	71.2	60.5	57.9	75.8	93.2	87.2	76.2
Буцалтгүй хувийн шилжүүлэг	0	0	-2.7	-0.1	-3	-2.8	6.2	4.2
Урсгал дансны тэнцэл	-651.4	-164.7	-90.7	-39.9	-40.3	-52.2	-99.3	-20.7
Буцалтгүй улсын шилжүүлэгв цэвэр	7.4	41.6	37.9	71	77.7	79.1	63.6	47.7
Албан ёсны тусламж	7.4	41.6	38.7	66.7	69.5	70.9	56.2	
Бусад цэвэр шилжүүлэг	0	0	-0.8	4.3	8.2	8.2	7.4	
Хөрөнгийн данс	583.5	106.9	30.7	-9.6	-36.1	19	20.3	69.2
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	0	0	2	7.7	7	9.8	15.9	25
УДХ зээл	516.7	130.3	86.3	32.5	7.9	50.9	46.8	79.3
Хуваарилалт	537.4	139.6	112.1	54	60.3	96.2	84.1	166.2
Ашиглалт	20.7	9	25.8	21.5	52.4	45.3	37.3	36.9
БХ хөрөнгө	66.8	-23.4	-57.6	-49.8	-51	-41.7	-42.4	35.1
Зөрүү	7.3	-55.9	9.5	3.2	-8.7	-15.9	-4.4	32.1
Нийт тэнцэл	-53.3	-92.1	-12.6	24.7	-7.5	30	-19.8	64.1

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, Монголбанк (1997)

Практикаас үзэхэд төлбөрийн тэнцлийг тэнцвэржүүлэх түвшинд тохируулан валютын ханшийг зохицуулах, гадаад валютын нөөцийг хаах, бололцоо бүхий гадаад валютын тоонд норм тогтоох, валютын тухайн үеийн ханшинд тохируулан эрэлт, нийлүүлэлт зэрэг эдийн засгийн механизмын зохицуулалтыг хослуулан хэрэглэх нь тохиромжтой бөгөөд тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрхэн зохицуулахаа шийдэж болно.

Дараах үзүүлэлтээс манай улсын төлбөрийн тэнцлийн байдлыг авч үзвэл төдийлөн өндөр биш тогтворжих хандлага ажиглагдаж байсан бол 1996 оноос арай өөр байдал ажиглагдаж байна. Гадаад худалдааны тэнцлийн алдагдалын хувьд 1993-1995 онуудад бууралт гарч нааштай байдал гарсан байна.

Үүний зэрэгцээ урсгал тооцооны үзүүлэлт ч 1991 оныг бодвол алдагдал нь 50 гаруй хувиар буурсан тал харагдаж байна.

Хэдийгээр жилээс жилд монгол улсад хандивлагч улсуудын хандивын хэмжээ болон хөрөнгө оруулалт хэмжээ нэмэгдсээр ирсэн хэдий ч эдийн засгийн сэргэлт төдийлөн ажиглагдахгүй байгаа нь гадаад талаасаа Азийн эдийн засгийн хямрал нөлөөлсөн гэж үзэх талтай.

Монгол улсын гадаад эдийн засгийн байдлыг 1997 оны төлбөрийн тэнцэлд шинжилгээ хийж үзлээ. Энэхүү шинжилгээгээр төрөөс авч явуулсан эдийн засгийн гадаад, дотоод бодлогууд гадаад эдийн засгийн нөхцөл байдлуудыг харуулахыг эрмэлзэв. Үүнд:

Худалдааны тэнцэл

Төлбөрийн тэнцлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бол урсгал тооцоо тэр дундаа худалдааны тэнцэл юм. Нээлттэй жижиг эдийн засаг бүхий Монгол улс нэлээд оронтой худалдаа хийж байна. Эндээс эдгээр орнуудын инфляцийн түвшин болон валютын ханшны байдал Монголын эдийн засагт нөлөөлөх нь дамжиггүй юм. Тухайлбайл манай улс 1997 онд нийт 493.7 сая ам.долларын экспорт, 503.3 сая ам.долларын импорт хийгдэж, гадаад худалдааны тэнцэл нь 9.6 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Гадаад худалдааны нийт эргэлт 1996 оныхоос 6.7 хувиар өссөн байна. Экспорт өмнөх оноос 70.3 сая ам.доллар буюу 17 хувиар өссөн бол импорт 7.5 сая ам.доллар буюу 1.5 хувиар буурчээ. Үүнийг дараах хүчин зүйлээр тайлбарлахыг хичээв.

1. Төгрөгийн ханшны уналт, худалдан авах чадвар буурснаар дам утгаараа импортод татвар оногдуулж, экспортод татаас үзүүлэхтэй адил юм. Яагаад гэвэл манай улсын ханшны уналт нь гадаад орнуудад манай улсын бараа үйлчилгээг хямд болгож худалдан авах сонирхолыг өрнүүлэхэд хүргэдэг.
2. Зүүн Өмнөд Ази болон Зүүн Азийн бүсийг хамарсан хямрал. Эдийн засгийн хөгжлийн удаашрал, улс төрийн тогтворгүй байдлын улмаас 1997 оны 5 сараас Тайланд улсад эхэлсэн үндэсний валют болох баттын ханшны уналт нь цаашид даамжран Филиппин, Малайз, Сингапур, Индонез, Солонгос зэрэг улсуудад

нөлөөлж санхүүгийн хямрал үүсгэн үндэсний мөнгөн тэмдэгтийнх нь ханшийг унагасан. Энэхүү ханш уналт манай улсад эерэгээр нөлөөсөн бөгөөд 1997 оны IV улиралд эдгээр орон тэр дундаа Солонгосоос импортоор авах бүтээгдэхүүний хэмжээ ойролцоогоор 10 орчим хувь өссөн байна.

3. Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу импортын гаалийн татварыг үндсэнд нь тэглэсэн явдал нь гадаадаас янз бүрийн бараа үйлчилгээг өмнөх онуудыг бодвол харьцангуй ихээр оруулж ирэх гол шалтгаан болсон.
4. Дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнийн бууралт нь манай улсын экспортын 40 орчим хувийг эзэлдэг зэсийн баяжмалаас олох орлогыг бууруулсан төдийгүй экспортолсон зэсийн хэмжээ ч буурч түүнийг дагалдан орлого ч буурсан. Үүнээс гадна Зүүн Азийн хямралаас болж эдгээр орнууд нөөцөлсөн алтаа дэлхийн зах зээлд борлуулах болсноор алтны дэлхийн үнэ буурахад хүрч манайд сөргөөр нөлөөлсөн. Үүний зэрэгцээ ноолуурын экспорт 1997 онд ч зохих нөлөө үзүүлсэн.

Хэдийгээр иймэрхүү хүчин зүйл нөлөөлсөн ч уул уурай болон хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортын өсөлтийн дүнд экспортын өсөлт ажиглагдаж байна. Ийнхүү Монгол улс 1997 онд дэлхийн 65 оронтой худалдаа хийснээс 16 оронтой хийсэн худалдаа ашигтай, 49 оронтой хийсэн худалдаа алдагдалтай байна. 1998 оны гүйтцэтгэлээр гадаад худалдааны алдагдал 120.1 сая ам.доллар хүрсэн нь өмнөх 1997 онд олсон амжилтаасаа ухарсан гэж үзэж болохоор болсон байна.

Үйлчилгээ ба орлого

1997 онд үйлчилгээний орлого 60.9 сая ам.доллар, зарлага 76.2 сая ам.доллар бол үйлчилгээний тэнцэл 15.3 сая ам.долларын алдагдалтай байна. Энхүү алдагдлыг хүчин зүйлээр нь авч үзвэл:

1. Зах зээлд шилжсэнээр манай улс гадаад зах зээлд нээлттэй болж манай улсад жуулчлах жуулчдын тоо эрс нэмэгдсэнээр энэ чиглэлийн орлого нэмэгдсэн. Гадаадаас ирж байгаа жуулчдын дийлэнх хэсгийг Японы жуулчид эзлэж байгаа бөгөөд зуны улиралд энэхүү үзүүлэлт эрс нэмэгддэг. Иймд Монголд жуулчдыг хүлээн авах аятай нөхцөл бүрдүүлэх, орон нутгийн удирдлагыг уялдуулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлэх улмаар үндэсний орлогын зохистой бүтцийг хангахад төрөөс тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.
2. Гадаад улс орнуудад үзүүлж буй үйлчилгээний өсөлтийг хангахад манай улс Ази Европыг холбосон гол зангилаа болохын хувьд ачаа тээврийг өөрийн орны нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэхэд гадаадын авиа компаний дамжин өнгөрөх нислэг, төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлтэд анхаарлаа хандуулах нь чухал байна.
3. Манайд сүүлийн үед уналтад ороод байсан барилгын болон бусад салбарын уналт зогсож цаашид хөгжих бололцоо бий болж байгаатай холбогдон гаднаас энэ чиглэлээр ажиллах хүч болон үйлчилгээг худалдан авах болсон нь үйлчилгээний тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байгаад анхаарлаа сулруулахгүй ажиллах шаардлага тавигдаж байна.

Урсгал шилжүүлэг

1997 онд оршин суугчдаас гадаадад шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 0.4 сая ам. доллар болж өмнөх оноос 0.2 саяар буурсан байна. Албан ёсны буцалтгүй тусламжийн хэмжээ 41 сая ам.доллар болж 15.2 сая ам. доллараар буурсан байна. Үүнийг хүчин зүйлээр ангилж үзвэл:

Нэгдүгээрт: Зүүн Азийн эдийн засгийн хямралын улмаас манайд хандивлагч орнуудын хандавилах бололцоо буурсан.

Хоёрдугаарт: Авсан буцалтгүй тусламжийн зарцуулалтыг зориулалтын бус аргаар ашиглах явдал гардаг зэргээс буцалтгүй тусламжийн хэмжээнд нөлөөлсөн.

Санхүү хөрөнгийн данс

1997 онд шууд хөрөнгө оруулалт 25.0 сая ам.доллар болж өмнөх оноос 60 хувиар, дунд хугацаат зээл 79.3 сая ам. доллар болж 40.9 хувиар тус тус өсч 69.2 сая ам. долларын ашигтай гарсан байдлыг авч үзвэл:

1. Төрөөс хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих бодлого явуулж байгаагийн үр дүнд гадны хөрөнгө оруулалт өмнөх оноос 1.5 дахин өссөн байна. (1997 оны 6-р сард гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зохион байгуулсан)
2. Зээлийн ашиглалт нь 116.2 сая ам.долларын буюу өмнөх оноос 27.6 хувиар нэмэгдсэн байна. Гэхдээ энэхүү зээлийн ашиглалтын нэмэгдэл нь эргээд төлөгдөх хугацаа болоход төлбөрийн тэнцлийн алдагдалд нэрмээс болж эдийн засгийг хүнд байдалд оруулж болохыг анхаарах хэрэгтэй юм.

Энд нэгэн тоо баримт дурдахад манай улс 1997 онд гадаад зээлийн үндсэн төлбөрт 35.2 сая ам. доллар, хүүгийн төлбөрт 7.0 сая ам. доллар төлөхөөр байсан ба урьдчилсан гүйцэтгэлээр 145.2 сая ам. долларын зээлийг ашиглахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 116.2 сая. долларын зээлийг ашигласан байна. Хэрвээ 142.5 сая ам. долларын зээлээ бүрэн ашигласан тохиолдолд 1997 оны эцэст гадаад өрийн үлдэгдэл 602.3 сая ам.доллар болж, 1996 оны эцсийнхээс 73.8 саяаар нэмэгдэх байв. Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг нөхөх гол эх үүсвэр нь гадаадын зээл, албан ёсны тусламж, хөрөнгө оруулалт, гадаадаас хийгдэж буй санхүүжилт болж байна.

ОУВС-аас төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлалыг 1947 оноос хойш 5 удаа шинэчилсэнээс сүүлийнх нь 1993 онд "Balance of payments manual" гэсэн нэртэйгээр товхимол гарсан. Нэгдсэн аргачлалаар тооцохтой уялдан дэлхийн улсуудын төлбөрийн тэнцлийг харьцуулан үзэж улс бүрийн гадаад нийгэм, эдийн засгийн харилцаа ямар байгааг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой болдогоороо давуу талтай юм.

Монгол улсын төлбөрийн тэнцлийг хөгжлийн өөр өөр арга замаар явж ирсэн ОХУ, Сингапур, Герман, Унгар, АНУ зэрэг улсыг сонгоход эдгээр улс нь нийгэм, эдийн засгийн дараах онцлогтой байна. Тухайлбал: АНУ гэхэд л маш олон жил капиталист

эдийн засгийн хөгжлөөр явж ирсэн;

Герман улс дэлхийн II дайнаас хойш эдийн засгийн зүй зохистой бодлого явуулснаар дэлхийн тэргүүлэгч орнуудын нэг болсон;

Сингапур гэхэд сүүлийн 20-30 жилийн дотор огцом хөгжиж хөгжлийн өндөр түвшинтэй Азийн бар хэмээгдэх болсон;

Унгарын хувьд гэвэл тус улс нь социализмаас, зах зээлийн эдийн засагт шилжин эдийн засгийн өсөлтөөрөө бусад социалист гэгдэж байсан улсуудтай харьцуулахад нэлээд амжилттай явж байгаа;

ОХУ-ын хувьд гэвэл хуучин ЗХУ гэж байснаа задарсан мөн социализмыг тэргүүлэгч улс байсны хувьд эдийн засгийн үйл явц нь нэлээд өвөрмөц байдлаар илэрч байгаа;

Манай улсын хувьд нэг тогтолцооноос нөгөөд шилжиж байгаа. Энэ нь Унгартай адил төстэй мэт боловч хүн ам, нутаг дэвсгэрийн байршил, эдийн засгийн байдал, нийгмийн асуудал гэх мэтээр ялгаатай юм. Эдгээр улсуудын төлбөрийн тэнцлийг харьцуулан үзэхийн өмнө улс бүрийн төлбөрийн тэнцлийн онцлогийг авч үзлээ.

ЗХУ-ын үеийн Бүгд Найрамдах улсууд бие даасан тусгаар улсууд болсонтой холбогдон ОХУ хуучин Бүгд Найрамдах улсуудтай харилцсан харилцааг тусгасан төлбөрийн тэнцлийг мөн гадаад улсуудтай харилцсан харилцааг тусгасан төлбөрийн тэнцлийг тус тусад нь гаргадагаараа өвөрмөц юм.

ОХУ-ын 1994-1997 оны төлбөрийн тэнцэл нь ашигтай явж ирсэн байна. Энд гол нөлөөлөгч хүчин зүйл болох урсгал тооцооны данс 1994-1997 онуудад эерэг байгаа бөгөөд энэ хугацаанд барааны тэнцэл нь эерэг, үйлчилгээний тэнцэл нь сөрөг, хөрөнгө оруулалтын орлого болон хөдөлмөрийн хөлс нь сөрөг боловч дан ганц худалдааны тэнцлийн эерэг үзүүлэлтээр үйлчилгээний болон хөрөнгө оруулалтын орлогын сөрөг үзүүлэлтийг нөхөж чадсан байна.

Хөрөнгө санхүүгийн данс нь 1994-1996 онуудад дандаа сөрөг гарч байна. Өөрөөр хэлбэл гадагшаа хөрөнгө урсаж байсан бол 1997 онд энэ байдал өөрчлөгдөж хөрөнгийн дотогшлох урсгал ажиглагдаж эхэлсэн. 1994-1996 онуудад хөрөнгө санхүүгийн дансны алдагдалд барааны тэнцлийн эерэг байдал нөлөөлөн эцсийн дүндээ төлбөрийн тэнцэл нь эерэг дүнтэй гарч байв.

Сингапурын төлбөрийн тэнцэл нь 1996 онд өмнөх оноос 15 хувиар буурч байсан бол 1997 онд 1996 оныхоос 12 тэрбум ам.доллар буюу 14 хувиар өссөн. Өмнөх жилүүдийн адилаар урсгал тооцооны илүүдэл нь капиталын гадагшлах урсгалыг нөхөж байна.

1997 онд урсгал тооцоо 22 тэрбум ам.доллар буюу 5.6 хувиар өмнөх оноос илүү байв. Үүнээс 3.4 тэрбум ам.долларын өсөлт нь үйлчилгээнээс орсон ба хөрөнгө оруулалтын орлого их хэмжээгээр нэмэгдсэн. Мөн бусад тээвэр үйлчилгээнээс олох орлого ч хүчтэй өссөн. Бүтээгдэхүүний балансын хувьд нефтийн бүтээг-

дэхүүнд зарах зардал 3.0 тэрбум ам.доллар байсанаа 70 хувиар нэмэгдсэн ч үндсэнд нь үйлчилгээний өсөлтөөр нөхөж чадсан.

Хөрөнгө санхүүгийн дансны алдагдал 1996 онд 3.4 тэрбум ам. доллар байсан бол 1997 онд бараг 2 дахин өссөн байна. Сүүлийн жилүүдэд Сингапур дахь гадаадын хөрөнгө оруулалт байнга өсч байна. Тус улсад хөрөнгө оруулж байгаа улсуудаас Малайз, Гон-Конг хоёр эхний байрт орж харгалзан 20%, 14%-ийг эзэлж байгаа бөгөөд гурвадугаарт Индонези 9.4%-тай байна.

Герман улсын төлбөрийн тэнцэл 1992 онд 39504.6 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 1997 он гэхэд 4866.2 сая ам. долларын алдагдалтай гарч байна. Герман улс ерөнхийдөө экспортлогч улс бөгөөд цэвэр экспортын хэмжээ нь 1992 онтой харьцуулахад 5.5 дахин өссөн байна. Урсгал тооцооны баланс дахь хөрөнгийн орлого болон урсгал шилжүүлэг өндөр байдгаас шалтгаалан урсгал тооцооны данс нь сөрөг гардаг байна. 1992 онд Герман улсад гаднаас их хэмжээний хөрөнгө оруулалт орж байсан бол 1997 он гэхэд гадагш хөрөнгө оруулалт хийх нь нэмэгдсэн байна.

Унгар социалист системийн үед ерөнхийдөө тэнцвэртэй байсан төлбөрийн тэнцлийн тооцоо зах зээлийн эдийн засгийн системд шилжих явц эхэлсэнээр алдагдалд орох болсон. Үүний гол шалтгаан нь урсгал тооцооны алдагдал нь 1992 онд 3.5 тэрбум ам. доллар байсан бол 1993 онд 15 хувиар нэмэгдсэн байна. Энэхүү алдагдал нь 1994 он гэхэд ДНБ-ний 9.4 хувийг эзлэж байснаа 1997 он гэхэд 2.2 хувь болтлоо буурч чадсан.

Ер нь Унгарын хувьд 1995 он сэргэлтийн жил байсан гэж хэлж болно. Улс төрийн тогтвортой байдал, эдийн засгийн зөв бодлогоос шалтгаалан үйлдвэрлэл нь экспортын чиглэлийн болон импортыг орлуулах аж үйлдвэрийн өсөлттэй холбоотойгоор өмнөх оноос экспорт 70 хувь орчмоор өсч, импорт 40 хувь хүртэл буурсан нь гайхамшигтай өндөр амжилт юм.

Мөн үүний зэрэгцээ капиталын гадагшлах цэвэр урсгал (ашиг, ноогдол ашиг, зээлийн хүүгийн орлого гэх мэт) нь Унгарт жилээс жилд нэмэгдэж байгаа нь шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбоотой. Энэ нь 1997 он гэхэд 400 сая ам.доллар болж нэмэгдсэн.

Америкийн эдийн засаг нь дэлхийн эдийн засагт нөлөөлөгч чухал хүч юм. Энэ утгаараа гадаад эдийн засгийн үйл ажиллагаа нь тун эрчимтэй явагдаж байдаг.

Тус улсын хувьд төлбөрийн тэнцэл нь ихэнх тохиолдолд алдагдалтай гардаг. Үүний гол шалтгаан нь экспорлохоосоо илүү импортолдог, урсгал шилжүүлэг ихтэй (ядуу буурай орнуудад зээл, тусламж, хандив, буцалтгүй тусламж зэргийг ихээр олгодог гэх мэт), гадагш хийх хөрөнгө оруулалт нь орж ирж буй хөрөнгө оруулалтаасаа ямагт их байдаг зэрэгтэй холбоотой юм. Энэ ч чанараараа алдагдалаа нөхөхийн тулд холбооны нөөцийн системээс ихээхэн хэмжээний хүчин чармайлт тавидаг.

Харин манай улсын хувьд урсгал тэнцлийн алдагдал нь зах зээлд орохоос өмнө нэлээд өндөр хэмжээтэй байгаад зах зээлд шилжих явц эхэлсэнээр багассан ч алдагдал арилахгүй байна. 1997 онд хамгийн бага алдагдалтай буюу 20.7 сая ам. доллар болсон байна. 1997 онд худалдааны балансын алдагдал 9.6 сая ам. доллар болж өмнөх оноос бараг 89%-иар буурсан нь ОУВС-н аргачлалаар экспортод цэвэршүүлж гаргасан алтыг оруулсантай холбоотой юм. Хэрэв цэвэршүүлж гаргасан алтыг тооцохгүй бол худалдааны балансын алдагдал маань 16.8 сая ам. доллар болж 80 орчим хувиар буурч байна. Манай улсын үйлчилгээнээс олж буй орлогын дийлэнхийг Унгарын адил аялал жуулчлалаас олж байна.

Гэтэл Герман улсын хувьд барааны баланс нь эерэг гарч байгаа ч үйлчилгээний импортыг их хэмжээгээр авдагаас шалтгаалан үйлчилгээний тэнцэл нь сөрөг гарсан ч барааны тэнцлийн эерэг үзүүлэлтээр үйлчилгээний тэнцлийн сөрөг үзүүлэлтийг нөхөж чадаж байна. Урсгал тооцооны тэнцэл дээр урсгал шилжүүлгийн гадагшлах урсгал нь дотогшлох урсгалаас давсан учир бараа үйлчилгээний тэнцлийн эерэг байдлыг давж эцсийн дүндээ сөрөг гарч байна.

1997 оны байдлаар Сингапурын урсгал тооцооны илүүдэл нь 22 тэрбум ам. доллар байна. Үүний бараг 73.6% нь үйлчилгээний тэнцлийн илүүдэл байгаа нь үйлчилгээний үйл ажиллагаа гололдогийг харуулж байна. Гэтэл хөгжлийн өөр арга барилтай Герман Оросын хувьд барааны экспортын хэмжээг нэмэгдүүлэх замаар урсгал тооцооны алдагдалыг багасгаж ашгийг ихэсгэж байна.

Өндөр хөгжилтэй Герман Сингапурын хөрөнгийн данс алдагдалт гарч ОХУ, Монголын хөрөнгийн данс ашигтай гарч байгаа нь өндөр хөгжилтэй улсууд нь хөгжил сул улсууд руугаа хөрөнгө оруулалт ба санхүүжилтыг хийдэг нь харагдаж болохуйц байна. Тухайлбал, Сингапурын хөрөнгө санхүүгийн данс нь 7.0 орчим тэрбум ам. долларын, Германых 7.2 орчим тэрбум ам. долларын алдагдалтай гарч байхад Монголынх 69.2 сая ам. долларын ОХУ-ынх 4.2 тэрбум ам. долларын ашигтай гарч байна.

Зүүн Азид гарсан санхүүгийн хямрал, мөнгөний ханшны уналтаас шалтгаалан энэ бүс нутгийн орнуудын хөрөнгө оруулалт ихээхэн буурсан. Энэхүү байдал нь ч Сингапурын эдийн засагт нөлөөлж гаднаас оруулж буй багцын хөрөнгө оруулалт их хэмжээгээр буурсан байна. Сингапурын хувьд хөрөнгө санхүүгийн данс нь хэдий алдагдалтай гарч байгаа ч шууд хөрөнгө оруулалт гаднаас их хэмжээгээр орж байхад санхүүгийн хөрөнгө оруулалт болох багцын хөрөнгө оруулалтыг гадагш их хэмжээгээр хийж байгааг харуулж байна. Гэтэл Германых шууд болон багцын хөрөнгө оруулалт хоёрыг гаднаас авахаасаа гадаадад илүү их хэмжээгээр (Шууд хөрөнгө оруулалт – 33.2 тэрбум ам. доллар, багцын хөрөнгө оруулалт – 6.1 тэрбум ам. доллар) хийж байгаа юм.

Гадаад улс орнуудын төлбөрийн тэнцэлд чухал нөлөө үзүүлдэг багцын хөрөнгө оруулалт нь манайд урьд өмнө нь ердөө хийгдэж байгаагүй бөгөөд 1997 онд л анх удаа "Алтан тариа" ХК, "Монголын Цахилгаан Холбоо" ХК, "Бармаш" ХК-иудын

хувьцааг багын хөрөнгө оруулалт байдлаар гадаадаас хийсэн байна. Монгол улс ийнхүү 1997 оноос дэлхийн санхүүийн зах зээлд гарах үүд хаалга нээгдсэн гэж үзэж болохоор байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед манай улс нийгэм эдийн засгийн хөгжлийг тав таван жилээр төлөвлөж байсан нь тухайн үедээ ач холбогдол өгч байв. Зах зээлд шилжих үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөний байгууллага үгүй болж улс орны бүхий л үйл ажиллагааг бүхэлдээ төлөвлөхөө больж төлөвлөлтийн асуудал орхигдоход хүрсэн.

Аж ахуйн нэгжийн түвшинд төлөвлөлт улс орны хэмжээнийхийг бодвол эрчимжин өөрийн үйл ажиллагааны хэтийн төлвийн асуудлыг чухалд тавих болсон. Зах зээлийн эдийн засгийн шилжилт гүнзгийрэх тусам улс оронд хийгдэх төлөвлөлт улам хурцаар тавигдаж байна. Тэр дундаа гадаад харилцааны асуудлыг хөнддөг төлбөрийн тэнцлийн үзүүлэлтийг прогнозчлох нь нэн тэргүүний асуудал юм. Энэхүү судалгаанд төлбөрийн тэнцлийн хураангуй үзүүлэлт болох экспорт, импортын прогнозад анхаарлаа хандуулах болно.

Гадаад худалдааны тэнцлийг прогнозлоход 1991-1998 онуудын үзүүлэлтүүдийг ашиглан хэтийн хандлагад регрессийн шинжилгээний аргыг хэрэглэж экспорт, импортыг тус бүрд нь валютын ханшнаас хамааруулан тооцов. Гадаад худалдааны тэнцэлд валютын нэрлэсэн ханшны нөлөөллийг регресс, корреляцийн шинжилгээгээр авч үзлээ.

Импорт, валютын нэрлэсэн ханшны хоорондох корреляци хамаарал нь 0.49; экспорт, валютын нэрлэсэн ханшны хоорондох корреляци хамаарал нь 0.14 байна. Импорт, валютын нэрлэсэн ханшны регрессийн шугаман тэгшитгэл $Y_x = 352.4 + 0.166x$ байгаа ба эндээс мэдрэмжийн коэффициентийг тооцвол $Эа_1 = 0.179$ буюу валютын ханш нэгжээр өөрчлөгдөхөд импортын хэмжээ 17.9 хувь өөрчлөгдөх төлөв харагдаж байна.

Экспортын хувьд регрессийн тэгшитгэл нь $Y_x = 382.98 + 0.25x$ байна. Эндээс мэдрэмжийн коэффициентийг тооцвол $Эа_1 = 0.028$ буюу валютын нэрлэсэн ханш экспортын хэмжээнд 2.8 хувийн нөлөөтэй байна.

Экспортод нөлөөлөх хүчин зүйлсийн хувьд нөлөөлсөн гол хүчин зүйл болох зэс, алт, ноолуурын дэлхийн зах зээлийн уналттай уялдаатай гэж үзэх боломжтой. Энэхүү регрессийн шинжилгээний тусламжтайгаар гадаад худалдааны эргэлтийн богино хугацаатай прогноз хийж боломжтой юм.

Нийт эдийн засагт явагдаж буй үйл явцын хоорондын хамаарлыг судалж, эдийн засгийн цаашдын төлөв хандлагыг RMSM-X хэмээх загварыг ашиглаж ирээдүйн талаар үнэлгээ өгдөг.

Энэхүү загвар нь өрийн болон эдийн засгийн нийт гарцын гэсэн үндсэн хоёр гол загвараас бүрдэх бөгөөд өрийн загварт төлж болох өр, шинээр авч болох зээлийн

төрөл, хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийн байдал, хэтийн төлөвийг тодорхойлж харуулдаг. Харин эдийн засгийн гарцын дэд загвар нь хоорондоо харилцан уялдаа бүхий хэд хэдэн багц бүлгүүдээс бүрддэг.

RMSM-X загварт манай улсын эдийн засгийн хөгжлийн байдлыг богино, дунд, урт хугацааны байдлаар прогнозлон гаргасан байдаг.

RMSM-X загвараар:


1998 онд гадаад худалдааны эргэлт 1034.6 сая ам. доллар болж 1997 оныхоос 20 орчим хувь өсч, экспорт 485.3 сая ам. доллар, импорт 549.3 сая ам. долларт хүрч, гадаад худалдааны алдагдал 54.3 сая ам. доллар болох бөгөөд төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал ДНБ-ний 4 орчим хувь болж байна хэмээн тодорхойлсон.

Үүний зэрэгцээ 1999-2000 онд газрын тос, алт олборлолт болон уул уурхайн бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулснаар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, өсөх хандлагатай байна. Үүнтэй холбогдож гадаад худалдааны алдагдлыг бууруулах боломж 2000 оноос бүрдэх төлөвтэй хэмээн үзжээ.

RMSM-X загвар дахь МУ-ын гадаад худалдаа

	1997	1998	1999	2000
1. Гадаад худалдааны эргэлт	861.4	1034.6	1104.0	1192.6
Экспорт	418.0	485.3	525.1	567.2
Импорт	443.4	549.3	578.9	625.4
Алдагдал	-25.4	-64.0	-53.8	-58.2
2. Гадаад худалдааны бүтэц, хувь	100.0	100.0	100.0	100.0
Экспорт	48.5	46.9	47.6	47.6
Импорт	51.5	53.1	52.4	52.4


RMSM-X загвар дахь МУ-ын гадаад худалдаа




Хэрэв эдийн засгийг одоогийн суурь дээр үндэслэн ердийн өсөлттэй байна гэж төсөөлбөл доод хувилбар буюу 2020 оны түвшинд нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 5200 ам. доллар хүрэх төлөв байна. Энэ нь одоогийн дунд зэргийн хөгжилтэй орнуудын түвшин юм. Ер нь дээрх дээд, дунд, доод гэсэн 3 хувилбарын аль алинд нь газрын тосны олборлолт тусгагдсан бөгөөд эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарын бүтээгдэхүүний өсөлт зэргийг дагаад гадаад худалдаа эрчимтэй өсөх ирээдүй байна.

Энэхүү өсөлтийг графикаар харуулбал:


Дээд хувилбар
(сая ам.доллар)



Дунд хувилбарт
(сая ам.доллар)




Доод хувилбарт
(сая ам.доллар)



Ийнхүү гадаад худалдааны үйл ажиллагааг гурван хувилбараар авч үзэн гаргасны зэрэгцээ гадаад худалдааны тэнцлийг мөн прогнозчилсон байгаа юм.


Гадаад худалдааны тэнцэл



Гадаад худалдааны тэнцэл нь дээрх байдалтай байх бөгөөд экспортод газрын тос, эрдэс түүхий эдийн баялаг гол хувийн жинг эзлэхээр байна.

Мөн загварт авч үзсэнээр ДНБ-нд гадаад худалдааны алдагдалын эзлэх хувийн жинг тодорхойлон гаргасан байдаг.

ДНБ-нд гадаад худалдааны эзлэх хувийн жин



Энд эдийн баялагт тулгуурласан олборлох, боловсруулах салбарын бүтээгдэхүүн экспортод зонхилох хувийг эзлэхээр байна. Газрын тос, зэс, төмөрийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэн экспортолоход анхаарах нь чухал болж байна гэж уг загварт авч үзсэн байна.

Төлбөрийн тэнцэл тухайн улсаас бусад улс оронтой хийсэн гадаад харилцааг бүхэлд нь тусгадаг. Энэ ч утгаараа эдийн засгийн хөгжилд гол байр эзэлдэг бөгөөд эдийн засгийн бодлого боловсруулахад анхаарах асуудлын цөм нь юм.

Гадаад эдийн засгийн харилцаагаа өргөтгөхөд Монгол улсын засгийн газрын

хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны амжилт нь дан ганц улс төрийн бус нийгэм эдийн засгийн бодлоготой уялдаж байна. Тухайлбал 1990-1998 оны хооронд гадаад хөрөнгө оруулалтын өсөлт, гадаад худалдааны өрөгжилтийг бий болгож чадаж байна. Гэхдээ шийдвэрлэгдээгүй асуудлын нэг бол хөрөнгө оруулалтын ихэнх нь анхдагч секторт ноогдож байгаа нь Монгол улсыг ихэвчлэн түүхий эд, материал экспортлогч болгож байна. Тийм экспортоос хамааралтай байдал нь макро эдийн засагт уршиг тарина. Учир нь түүхий эд бараа материалын үнэ, үйлдвэрийн бараа таваарын үнээс эрс ялгаатай байдаг оршино.

Энэ нь эдийн засгийн бусад секторт нэвчиж, либералчлагдсан худалдааны нээлттэй дэглэмд хүрэх замыг нь явцууруулах магадлалтай. Үүнийг багасгах нэг чухал арга бол дан ганц цэвэр түүхий эд барааны бааз суурь экспортоос үйлдвэрийн барааны бааз суурь экспортод шилжих нь ач холбогдол өгөх боломж бүрдэнэ.

1989, 1990 онд нийт экспортын 30-40 хувьтай тэнцэх гадаад худалдааны алдагдалтай байсан нь хуучин ЗХУ-ын хөрөнгийн шилжүүлгээр нөхдөг байв. 1991 оноос энэ урсгал зогсоноор ганцхан жилийн дотор импортын хэмжээ бараг 60 хувиар буурсан.

Манай улсын гаалийн хууль тогтоомжуудын тогтворгүй байдал нь гадаад худалдаанд нөлөөлдөг. Тухайлбал импортын гаалийн татаврыг тэглээд ганц хоёр жил болов уу үгүй юу үндэсний үйлдвэрлэлийг сэргэхгүй байна, төсвийн орлогод нөлөөлөлж байна гэж үзэн буцаан импортын гаалын татаврыг өөрчлөхөд хүрсэн. Мөн үүний зэрэгцээ онцгой албан татварын хууль ч тодорхой хэмжээгээр өөрчлөгдөөд байна. Гэхдээ үүний нэг давуу тал нь гаднаас хүн ам, нийгэм эдийн засагт хортой зүйлийг хязгаарлаж байгаагаараа давуу талтай юм.

Төлбөрийн тэнцэлд чухал нөлөөтэй үзүүлэлтүүдийн нэг болох валютын ханш ч энэ хугацаанд нэлээд хэлбэлзэмтгий байв. Валютын чөлөөтэй хөрвөх тогтолцоонд шилжсэнээр мөнгөний ханш унах явдал гардаг. Үүний зэрэгцээ урьд нь байсан хар захын ханш ч зохих нөлөө үзүүлдэг юм. Хүснэгтэд 1 ам. доллартай харьцах төгрөгийн ханшийг харуулав.

Валютын ханш, 1 ам. доллар=төгрөг

Дундаж ханш	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Дундаж ханш	3	4	25	40	294	410	450	575	790	840	1021.8
Жилийн эцсийн	3	7	40	40	396	414	474	694	814	902	1072.4

Шилжилтийн эхний үе шатанд Засгийн газар валютын ханшийг тогтмол байлгах бодлогын хүрээнд банкны хоёр шатлалтай тогтолцоонд шилжсэн Гэвч 1993 оны 5 сарын 28-аас эхлэн ханшийг чөлөөлсөн. Ингэснээр төгрөгийн ханш эрс унаж инфляци өсөв. Энэ байдал үргэлжилсээр 1997 он хүрч байж л тогтворжиж эхэлсэн боловч 1998 онд Засгийн газар олон солигдсонтой холбоотойгоор хэлбэлзэлд орсон.

Гадаад валютын цэвэр нөөц 1992 онд 0.5 долоо хоногийн импорттой тэнцэх хэмжээнд хүртэл буурсан боловч 1993 оноос өсч эхэлсэн. Гэсэн хэдий ч энэ үзүүлэлт жил бүр янз янзын байдлаар хэлбэлзэж байна.

Гадаад валютын цэвэр нөөц

	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997
Цэвэр нөөц, сая доллар	49.3	20.5	4.23	27.2	37.2	70.6	56.8	107.2
Импортын долоо хоног	2.8	3.0	0.5	3.7	5.2	7.5	5.8	12.6

Төлбөрийн тэнцлийн үйл ажиллагаа тийм ч сайн бус байсан бөгөөд ОУВС-аас ямагт дэмжлэг үзүүлж байв.

Төлбөрийн тэнцлийг дэмжихэд зориулсан хөрөнгө

	1991	1992	1993	1994	1995	1996	1997
Дэмжлэг	49.3	20.5	4.23	27.2	37.2	70.6	56.8

Улс орон бүр гадаад үйл ажиллагаансаа ашигтай ажиллахыг эрмэлздэг. Гэвч энэ нь тийм хялбар зүйл биш бөгөөд дотоодод авч явуулсан бодлого, гадаад улс орнуудаас явуулж буй улс төр, эдийн засгийн бодлогоос ихээхэн хамаарч байдаг.

Манай улс жижиг эдийн засагт гадаад эдийн засгаас нэлээд өндөр хамааралтай байдаг тул өөртөө аль болох ашигтайгаар эргүүлж төлбөрийн тэнцлээ ашигтай гаргахыг эрмэлзэх нь чухал. Тухайлбал Зүүн Азийн хямрал гарснаар 1997 оны 11 ба 12 сард манайд орж ирсэн хөрөнгийн урсгал өмнөх саруудынхаас их байгаа нь үүнтэй холбоотой гэж үзэж болохоор байна. Өнөөгийн нөхцөлд дараах үндсэн хүчин зүйлүүдийг авч хэрэгжүүлэх замаар төлбөрийн тэнцлийг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

1. Төгрөгийн ханшийг тодорхой түвшинд хүртэл унагах. Энэ нь манай бараа үйлчилгээний үнийг гадаадад хямд болгож экспортыг нэмэгдүүлнэ.
2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх. Монголд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, ингэснээр үйчилгээний орлогыг өсгөх боломжтой болно.
3. Хөрөнгө оруулалтыг дэмжих. Төрөөс хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих бодлого явуулах.
4. Зээл ашиглалтын зохистой бодлого явуулах. Зээлийг зөв зохистой ашиглахгүй бол тухайн үед төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөтэй ч эргэн хүүгийн хамт төлөх цаг иэрэхэд төлбөрийн тэнцэл төдийгүй улсын эдийн засгийг ч хүнд байдалд оруулна.

Ойрын хугацаанд манай улс газрын тос, алт олборлолт, уул уурхайн бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулбал экспортын бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, өсөх хандлагатай болно. Үүнтэй холбогдож гадаад худалдааны алдагдлыг бууруулах боломж дээшлэнэ. Тухайлбал судлаачдын тооцоолсноор

Хятад руу дор хаяж 1 нефтийн хоолой татахад ойрын 10 жилийн дотор экспортын орлогыг 750 сая ам. доллараар, төсвийн орлогыг 300-400 сая ам. доллараар нэмэгдүүлэх боломжтой байгаа юм.

Ашигласан материал

1. "Монгол банкны 1997 оны жилийн тайлан"
2. "Макро эдийн засгийн бодлого, санхүүгийн программчлалын семинар"
3. "Монгол улсын 1998-2000 оны хөгжлийн загварчлал"
4. "Balance of payments manual" *International Monetary Fund Fifth edition. 1993*
5. "Россия в цифрах" (официальное издание). Москва, 1998 г.
6. "Российский статистический ежегодник" (официальное издание), 1996 г. *гомкомстат России, Москва.*
7. "Hungary 1997" *Hungarian central Statistical office. 1998.*
8. "Singapore 1997 Statistical highlights" *Singapore department of Statistics.*
9. Монгол эдийн засаг "Шилжилтийн эдийн засгийн гарын авлага" УБ, Манчестр, 1999.
10. Статистикийн жилийн эмхэтгэл ба бюллетенүүд.
11. "Үндэсний тооцооны систем" Б.Батмөнх, Б.Машир. УБ хот, 1995.